



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 07

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 950,651,751 /есөн зуун тавин сая зургаан зуун тавин нэгэн мянга долоон зуун тавин нэг/ төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, эд хөрөнгийг хавсралтын дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Б.Цэцэгжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

4

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны... дүгээр сарын
...ний өдрийн... тогтоолын хавсралт



Дундговь аймгийн Баянжаргалан сум Хүүхдийн цэцэрлэг

Барилга байгууламж:

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Цэцэрлэгийн барилга	ш	791,816,974	1	791,816,974
2	Гадна холбоо	м	17,236.51	180	3,102,572
3	Гадна цахилгаан	м	17,088.41	360	6,151,827
4	Халаалтын тогоо	ш	18,366,770.5	2	36,733,541
5	Гадна бохир ус шугам	м	48,539.71	140	6,795,559
6	Гадна зам талбай	м2	129,252.15	220	28,435,473
7	Гадна гэрэлтүүлэг	ш	363,636.36	11	4,000,000
8	Гадна цэвэр шугам	м	20,000	50	1,000,000
9	20м2 бохир цооног	м2	1,143,276.25	20	22,865,525
10	Хашаа	м	68,966	580	40,000,280
11	Сүүдрэвч	ш	2,000,000	2	4,000,000
Барилга байгууламжийн дүн				1566	944,901,751

Тоног төхөөрөмж:

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Камер	ш	150,000	5	750,000
2	Камерийн сервер, дэлгэц	ш	600,000	1	600,000
3	Бойлуур	ш	300,000	5	1,500,000
4	380ийн мотор	ш	2,900,000	1	2,900,000
Тоног төхөөрөмжийн дүн				12	5,750,000

Нийт өртөг: 950,651,751₮